# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр Дугаар А/416 Хэрлэн сум

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх
“Шуурхай баг” байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Зэрлэг амьтны нөлөөллөөс хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх, ховор, нэн ховор амьтдыг эрсдэлээс хамгаалах ажлыг шаардлагатай тохиолдолд шуурхай зохион байгуулах багийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч | С.Амгаланбаатар | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын Улсын ахлах байцаагч |
| Нарийн бичгийн дарга | Б.Нандинбаатар | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд | И.Сүхбат | Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн Ахлах байцаагч, Цагдаа ахмад |
| | М.Мөнхбат | Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахлах хошууч, |
| | Э.Батдаваа | Мал эмнэлгийн газрын Өвчний мэдээ тайлан, цахим бүртгэл хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн |

2.Шуурхай багийн ажлын зардлыг гүйцэтгэлээр тооцож, Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй.


231011107

3.Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж, байнгын бэлэн байдлын хангаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (С.Амгаланбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ